



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын
гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх
үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2020 оны 217, 2023 оны 301, 442 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх үүрэг бүхий Үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн сүүлийн хагас жилийн үнэлгээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор хянаж, баталгаажуулахыг Үнэлгээний баг (Л.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

3. Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн үнэлгээний 85-100 буюу "Маш сайн", 70-84 буюу "Хэвийн", 70 хүртэлх оноог "Хангалтгүй" үнэлгээний ангилалд тус тус хамруулан тооцохыг Үнэлгээний баг (Л.Отгонбаяр)-т даалгасугай.

4. "Маш сайн" үнэлгээнд хамрагдсан албан хаагчдын сүүлийн хагас жилийн үр дүнгийн урамшууллыг албан тушаалын үндсэн цалингийн 100 хүртэлх хувиар, "Хэвийн" үнэлгээнд хамрагдсан албан хаагчдын сүүлийн хагас жилийн үр дүнгийн урамшууллыг албан тушаалын үндсэн цалингийн 50 хүртэлх хувиар тус тус тооцон олгохыг, "Хангалтгүй" үнэлгээнд хамрагдсан албан хаагчид урамшуулал олгохгүй байхыг Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн тасаг (А.Азжаргал)-т даалгасугай.

5. Үнэлгээний үр дүнг байгууллагын дотоод мэдээллийн сүлжээгээр нээлттэй мэдээлэх, гарсан алдаа дутагдлыг арилгах, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх санал, зөвлөмж боловсруулах, чадавхыг дээшлүүлэх арга хэмжээг дараагийн тайлант хугацаанд байгууллагын төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхийг Үнэлгээний баг (Л.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

6. Үнэлгээний багийн дарга, гишүүд болон нарийн бичгийн дарга нь нууцын баталгаа гарган, мэдээллийн давуу байдлаа ашиглан албан хаагчдын үнэлгээний дүн баталгаажихаас өмнө үнэлгээний дүн болон үнэлгээний үйл явцтай холбоотой аливаа мэдээллийг задруулахгүй байхыг Үнэлгээний багийн гишүүдэд үүрэг болгосугай.

1720020379


7.Энэ тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/55 дугаартай тушаалыг хүчингүйд болсонд тооцсугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.БУЯНТ

Засаг даргын Тамгын газрын даргын 2024.
оны 18 дугаар сарын 28 -ны өдрийн.....
...тушаалын хавсралт



Үнэлгээний багийн бүрэлдэхүүн

Үнэлгээний багийн дарга:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Архивын хэлтсийн дарга

Нарийн бичиг:

Хүний нөөц, хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан
ахлах мэргэжилтэн